

Зуух-Зоогийн неолитын суурин нь бидний дээр өгүүлсэнчлэн МЭӨ IV—III мянган жилд холбогдох ба харин бидний тусгайлан авч үзэх буй зэс хайлуулах зуух тус суурингийн хамгийн сүүл үед өөрөөр хэлбэл зэс хайлуулж эхэлсэн үед тухайлбал, МЭӨ III мянган жилд хамаарах бололтой.

Дээрх баримтанд үндэслэн Монгол оронд МЭӨ III мянган жилд анхны төмөрлөг болох зэс хайлах ажил неолитын аймгуудын дунд бие даан үүсчээ гэж үзэж болох юм.

**МОНГОЛ ЗОХИОГЧИЙН ТӨВД
ХЭЛЭЭР БИЧСЭН САНСКРИТ
ХЭЛНИЙ ЗҮЙН НЭГЭН БИЧГИЙН ТУХАЙ
Р. Бямбаа**

«Шинжлэх ухаан амьдрал» сэтгүүлийн 1985 оны № 1-т «ӨВ СОЁЛ» буланд УННС-ийн орлогч захирал Ш. Базар «ҮНЭТ ХОВОР СОНИН НОМУУД»¹ гэсэн нэртэй өгүүлэл нийтлүүлсэнээс хойш хэдэн жил өнгөрч байна. Энэхүү өгүүлэлд эрдэм шинжилгээний хүрээнд урьд өмнө орж байгаагүй судалгаа шинжилгээний нэн чухал ач холбогдолтой үнэт ховор сонин номны нэг болох санскрит хэлний зүйн нэгэн бичгийн тухай «...гавьж Дамдинсүрэнгийн (XX зуун) «Янжиндогийн тайлбар»-зэрэг санскрит хэл зүйн бүтээлүүд... УННС-д)» бий гэж дурдсан байна.

Үүнээс өмнө уг номын болон зохиогчийн талаар Гандантэгчилин хийдийн хамба лам агсан С. Гомбожав (1903—1980) ОУМХБ-гийн эрдэмтдийн анхдугаар их хуралд тавьсан илтгэлдээ «ДАМДИНСҮРЭН, Их Хүрээний гавьж, 20 дугаар зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, эмийн тайлбарын алдааг зассан ба **санскрит үсгийн зүйн тайл-**

Рагчаагийн Бямбаа. ДДСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

1. Д. Дорж, Д. Цэвээндорж. Отчет палеолитического отряда МСИКЭ-ций за 1985 год. (ТХГЕФ)
2. А.П.Окладников. Неолит и бронзовый век Прибайкале МИА 18 М. Л. 1950, стр. 139--190
3. А. П. Конопацкий. Древние культуры Байкала, Новосибирск, 1982., стр. Т1—72
4. А. П. Окладников. Неолит и бронзовый век Прибайкале МИА. № 18 М-Л. 1950, стр. 139—190
5. Д. Дорж, Неолит восточный Монголи, УБ., 1971, стр. 77, 114-125, 140—150.
6. Х. Пэрлээ. Монголын нүүдэлчдийн металлурги, металл боловсруулалтын түүхийн асуудалд АС, ТХ ф-- 4 тал 48—73
7. Х. Пэрлээ. Дурдсан зохиол 48—49-р талд.
8. Х. Пэрлээ. Монголын эдийн боловсролын хоёр нэр томъёо, Бух дарах. Гурван өгүүлэл, «Студия Монголико» т. III. Ф, 13—15. УБ., 1962 тал 43—44

бар дүрэм зэрэг, зарим нь бартай, **зарим нь бичмэл**² гэж өгүүлсэн ба энэ нь анх гавьж Дамдинсүрэнгийн нэрийг Монголыг судлагч эрдэмтдийн сонорт хүргэсэн билээ. Мөн Академич Ц. Дамдинсүрэн «Ганжуурын төвд хэвлэлд хийсэн Дандар аграмбын ариутгал» (шүүдэг)³ гэдэг өгүүлэлдээ гавьж Дамдинсүрэнгийн Ганжуурын ариутгалын тухай дурдсан байна.

«Шинжлэх ухаан амьдрал» сэтгүүлд дээр нэр дурдсан өгүүллийг нийтлэгдэхээс өмнө би санскрит хэлний зүйн энэ бичгийг сонирхож байсан болохоор акад. Ц. Дамдинсүрэн гуайгаас 1984 оны сүүлчээр уг номын талаар асууж лавлахад, «Дамдинсүрэн гавжийг (Янжиндогийн тайлбар) гэдэг ном хийсэн гэдгийг дуулсан, өөрийн гараар барьж, нүдээр үзээгүй болохоор сайн мэдэхгүй юм. Надад хорин хэдэн хуудастай (Янжиндогийн тайлбар) бололтой нэг багавтар бичмэл ном байсан юмсан, одоо тэр маань хаа байгааг мэдэхгүй, ямарч л байсан Хүрээний Бизья аймгийн их лам Дамдинсүрэн гуайн ном биш байсан» гэж хэлсэн юм.

Харин би Их Хүрээний гавьж Лувсандаш (XIX зууны үе) гуайн бичсэн «Янжиндогийн хоёр тайлбар»⁴ бичмэл, бар хоёрыг үзсэн болохоор Ц. Дамдинсүрэн гуайд байгаа тайлбарыг тэр хоёр тайлбарын аль нэгний хуулбар байх гэж бодсон тул түүнийг олж үзэх талаар дахин хөөцөлдөөгүй билээ. Гэтэл энэ ярианаас хойш нэн их удаагүй байхад «ШУ Амьдрал» сэтгүүлд дээр нэр дурдсан өгүүлэлд «Дамдинсүрэн гавьж «Янжиндогийн тайлбар»-ын тухай өгүүлснийг үзээд, уг номыг УННС-ийн төвд хөмрөгөөс үзэх гээд олж үзэж чадаагүй билээ. Харин өөр зохиогчдын бичсэн «Янжиндогийн тайлбар» хоёр гурав байхыг үзсэн.

Их Хүрээний гавьж Дамдинсүрэнгийн «Янжиндогийн тайлбар» миний сонирхлыг улам их татаж, түүнийг эрж сурвалжлах ажлыг орхилгүй үргэлжлүүлсээр байв. Энэ эрэл талаар болсонгүй уйгагүй эрж сурвалжилсны эцэст зохиогчийн бүтээлийн хоёр гарчиг «Янжиндогийн тайлбар»-ын хамт олж үзэх завшаан олдов.

Иймд тэрхүү хоёр гарчгийг эхлээд танилцуулахыг хүснэ. Үүний өмнө гавьж Дамдинсүрэнгийн (1854-1943) зохиол бүтээлийн талаар холбогдол бүхий мэдээг өөрсдийн бүтээлдээ дурдсан судлаачид түүний бүх зохиолын товъёог буюу гарчгийн тухай асуудлыг огт хөндөөгүй байна. Энэ нь зохиолчийн бүтээлийн товъёог, гарчиг зохиогдсоноосоо хойш урт удаан хугацааны туршид хувийн номын санд хадгалагдаж байсан маш цөөн хувь гар бичмэлээр хуулбарлагдан уламжлагдаж ирсэн зэрэгтэй холбоотой буй заа. Энэ гарчиг нь УННС-гийн төвд, монгол хөмрөг. Гандантэгчилэн хийдийн номын сан, болон аль ч номын санд байхгүй байна.

Нэгдүгээр гарчиг

Гарчгийн нэр нь: **dka' bcu rTa-mgrin bsrung gi gsung thor bu'i dkar chag**

«Гавьж Дамдинсүрэнгийн зарлиг хэсэг бусагийн гарчиг». Энэ гарчигийн хэмжээ нь 18,5x8 см бүгд 2 хуудас (4 тал), эхний нүүрэнд нэр, төгсгөлийн талд 6 хагас мөртэй, 2 тал нь тус бүр 7 мөрөөр бичигдсэн. Бичгийн хэв тогтуун, гаргац сайтай, орос цагаан цаасан дээр

хятад хар бэхээр бичсэн болно. Энэ гарчигт зохиогчийн нийт 22 бүтээлийн нэр орсон байгаа бөгөөд зохиогчийн зохиол бүтээлийн талаар анхны мэдэгдэхүүн өгөхөд хангалттай баримт юм. Гэвч энэ гарчгийн дутагдалтай тал нь номын нэрийг товчлон бичсэн ба бар, бичмэлийн алин болохыг тодорхойлоогүй, хуудасны тоо тавиагүй байгаа юм.

Хоёрдугаар гарчиг

Гарчгийн нэр нь: **mkhasgrub chen po bka' 'gyur pa dka' bcu Ngag dbang-rta-mgrin-brsung dpal bzang po'i gsung rtzom gyi dkar chag rgyud yig**

«Их мэргэн бүтээлч Ганжуурва, гавьж Агваандамдинсүрэнгийн зарлиг төдийн гарчиг, дамжлагын үг сэлт оршивой»

Гарчгийн хэмжээ нь 31,5x9,2 см, бүгд хоёр хуудас (4 тал) эхний нүүрэнд нэр, төгсгөлийн талд дамжлагын үг (**brgyud yig**) -ийг дөрвөн мөрөөр бичсэн, гаргац сайтай, орос цагаан цаасан дээр хар бэхээр бичсэн. Уг гарчигт зохиогчийн нийт 28 зохиолын нэр бичигдсэн байна.

Энэхүү гарчигт өмнө өгүүлсэн гарчгаас нэлээд хэдэн номын нэр илүү орсон, нэрийг бичихдээ гүйцдээр нь бичсэн бөгөөд барлагдсан номыг «бар» гэж бичээд хуудасны тоог тавьсан зэрэг давуу тал байна. Гэвч зарим номын нэрийг хураангуй бичиж, бар бичмэл алин болохыг заагаагүй болон хуудасны тоог бичээгүй зэрэг дээр дурдсан гарчгийн дутагдлыг давтсан байна. Гарчгийн хадгалалт хамгаалалт муу байснаас болоод усанд оруулж, ялзруулж 4, 5 хэсэг болгон үйрүүлсэн, зарим уранхайг сүүлд нийлүүлэн наасан, зарим үйрмэгийг алга болгосон байна.

Хоёрдугаар гарчгийн өмнөх гарчгаас давуутай болохыг цөөн хэдэн жишээн дээр авч үзвэл: 1-р гарчиг (1. г) **thub dbang gnas brten bcu drug gi phyag mchod** гэж байхад 2-р гарчигт (2.г) **thub dbang gnas brten bcu drug 'khor bcas la mchod cing gsol ba btab pa'i tsul don gnyis hun grub ma...31/** гэж дэлгэрэнгүй бичсэн, (Г.) **-bka gyur rin po bklag tsul gyi cho ga rgyas bring bsdus gsum** гэж байхад 12 г/-т **bka' gyur rin po che'i bklag tsul gyi cho ga rgyas 'bring bsdus gsum spar...19//** гэж номын нэрийг гүйцэд бичсэн ба бар, хуудасны тоо зэргийг бичсэн байв.

Иймд уг гарчгийн эхийг латин галигаар буулгаж хавсаргав.

Харин бидний гол анхаарал татаж байгаа «Янжиндогийн тайлбар» энэ хоёр гарчигт адил нэртэйгээр орсон бөгөөд бичмэл, бар алин болохыг тодорхойлоогүй, хуудасны тоо ч тавиагүй байна.

Гэтэл Дамдинсүрэн гавжийн энэ чухал зохиолын бүрэн бүтэн эх төвд хэл дээр гар бичмэлээр байгаа ажээ. Бид үүнийг зохиогчийн шавь болон, танил хүмүүсээс сурвалжилж байж саяхан нэг судар олж үзсэн учир гавьж Дамдинсүрэн «Янжиндод тайлбар» хийсэн нь үнэн бөгөөд уг зохиол одоо зарим нэг хувь хүний номын санд байгааг баталгаа болгож танилцуулах зорилгын үүднээс энэ удаа төгсгөлийн үгийг гаргалаа.

Уг бичмэл судрын бүтэн нэр нь:

Slob dpon Anubhuti'i 'grel pa gsal ldan gyi lde mig

«Анубүхтийн тодорхой тайлбарын түлхүүр оршивой»

Цаасны хэмжээ: 56x 10,5 см

Эх бичгийн хэмжээ 48,6x8 см

Хуудасны тоо: 120

Нэг талд орсон мөрийн тоо: 7

Эх бичгийн тухайд бол бичгийн хэв тогтуун, гаргац сайтай, орос цагаан цаасан дээр хар бэхээр бичигдсэн, үг үсгийн алдаа мадаггүй, харин зүүлт оруулга маш ихтэй, элдэв зураг чимэг, тамга байхгүй ба хуулбарлагдсан эх болно.

Уг номын нэрийн тухайд бол өмнө дурдсан гарчигт буй нэртэй үндсэндээ адил боловч Ловон (**slob dpon** багш) гэдэг үгийг нэмж бичсэн байна.

Янжиндо («сан **Sarasvativyčkarān asutra, te. brda sprod pa'i bstan bcos chen po dbyangs can gyi mdo**, мон. Дохио учруулах эгшигт судар»)⁵ хэмээх энэ зохиолыг энэтхэгийн хэл шинжлэлтэн Анубүхти (Anubhuti VII зууны үе) 5 бүлэгтэй шүлэглэсэн байдлаар зохиосон ба зохиогч уг зохиолдоо («сан. **Sarasvativyakaranasutravritti, тө. brda sprod pa'i bstan bcos chen po dbyangs can mdo bya ka ra na'i 'grel pa rab tu gsal ldan zhes bya ba bzhugs so/** мон. Дохио учруулахын шастир эгшигт жагаранагын тайлбар машид тодорхой»)⁶ гэсэн тайлбарыг бичсэн байна, Үүнээс хойш уг зохиолд Төвд, Монголын олон эрдэмтэд тайлбар бичсэн байна. Харин бидний өгүүлж байгаа тайлбар бол «машид тодорхой» тайлбарыг ойлгоход амар хялбар болгон зохиосон ба энэ нь ч уг зохиолын «түлхүүр» гэдэг нэрээс тодорхой байна.

Энэ зохиолыг гавьж Дамдинсүрэн зохиосон гэдгийг батлах баримт төгсгөлийн үгэнд байгаа тул сийрүүлбэл: «(119b—120a)...lde mig 'di ni **Sde-srid Sangs-rgyas-rgya-mtso'i mtsams sbyor lnga pa'i 'grel pa dang dBangs-can-dga'-ba'i-blo-gros kyi A-smad ya-shmad kyi 'grel pa;sogs dang//bya-brel-ba Blo-bzang-rin-chen dang Tsa-rgur-pa skal bzang-'phring-las gnyis kyi mchan dang A-khu-tsan Shes-rab-rgya-mtso'i mchan bris ma dang/ bdag gi bla ma sNgags-ram-pa bsTan-dar gyi mchan skor ma dang/ dka'-bcu smra ba Blo-bzang-bkra-shes kyi zur mchan rnam kyi nang nas cung zad btus te RTA-MGRIN-BSRUNG gyis bris pa yin no// 'di bris dge bas gro ba kun// legs sbyar lta yi skad shes nas//sangs rgyas gsung la thos sogs kyis// bzhags nas sangs rgyas myur thob shog//zhus dag yang yang bya dgo so//**

Үүнийг монголоор орчуулбал: (...түлхүүр үүнийг Дэсрид Санжайжамц (1653—1705) -ийн завсрын таван найруулгын тайлбар, Янжингайвийлодойн (XIX зууны үе) **A-smad, ya-shmad**-ийн тайлбар тэргүүтэн, Жабаралва Лувсанринчин (?), Цагүрва Галсанпэрилэй (?) хоёрын тайлбар, Ахүцан Шийравжамц (1803—1875)-ийн зүүлтэд тайлбар, гавьж Лувсандаш (XIX зууны сүүл XX зууны эхэн үе) тайлбар нугуудаас өчүүхэн төдий хурааж Дамдинсүрэн бичсэн болой) гэжээ.

Үүнээс үзэхэд «Янжиндогийн тайлбарыг» гавьж Дамдинсүрэн Төвдийн Дэсрид Санжайжамц, Ажа Ёнзин Янжингайвийлодой, Ахүцан Шийравжамц, монголын Дандар аграмба, гавьж Лувсандаш нарын зэрэг эрдэмтдийн бичсэн тайлбарыг үндэслэн зохиосон нь илэрхий.

Харин зохиогч уг номоо хэдийд, хаана зохиосноо тодорхой бичээгүй байна. Аман мэдээ болон зохиогчийн зарим нэг зохиолын төгсгөлийн үгнээс үзвэл зохиогч ихэнх зохиолоо 1900—1930 оны хооронд зохиосон бололтой. Иймд уг зохиолыг энэ үед зохиосон гэж таамаглаж болох юм.

«Янжиндогийн тайлбарын» төгсгөлийн үгийг энд гаргаж тавихад бидэнд шинээр ажиглагдаж байгаа хоёр зүйл байна. Нэгдүгээрт: Төвдийн эрдэмтдээс Янжиндод бичсэн тайлбарын дотор Ахүцан Шийравжамцын бичсэн тайлбар гэж өмнө мэдэгдэж байгаагүй ба ийм номын нэр зохиогчийн бүрэн зохиолын эмхтгэл буюу «сүнбум», «сүнбумын» гарчиг аль алинд байхгүй байна. Дамдинсүрэн гавьж «Ахүцан Шийравжамцын бичмэл тайлбар» гэж өөрийнхөө номын төгсгөлийн үгэнд бичсэнээс дүгнэж үзвэл: а) Дамдинсүрэн гавьж өөрийнхөө номыг зохиоход уг номыг ашигласан нь гарцаагүй; б) Уг ном манай улсад гар бичмэлээр уламжлагдсан ба төвдөд ч бар гараагүй гар бичмэлээр байдаг байсан байж магадгүй; в) Төвд хүний ном, тэгэхдээ зохиогчийн бүтээлийн эмхтгэлд ороогүй мөртлөө монгол газар гар бичмэлээр уламжлагдаж ирсэн явдал бол маш чухал ховор зүйл тул түүнийг эрж сурвалжлан олж, судалгааны хүрээнд оруулбал нэн чухал юм. Хоёрдугаарт: гавьж Дамдинсүрэн мөн төгсгөлийнхөө үгэнд «Миний багш аграмба Дандарын тайлбар...» гэж бичсэнийг дүгнэж үзвэл: а) Энэ аграмба Дандар гэдэг бол Ханд чин вангийн Дандар аграмба буюу 13-р Далай ламын багш чин вангийн Шадавдандар гэж алдаршсан хүн бололтой; б) Аграмба Дандар нь Шадавдандар мөн гэж үзвэл түүний гурван боть «сүнбум»-д болон «сүнбум»-ын гарчигт «Янжиндо»-гийн тайлбартай холбогдол бүхий ямар нэг ном байхгүй байна; в) Дандар аграмбын бичсэн зарим нэг ном зохиогчийн «сүнбум»-д ороогүй байдаг бөгөөд тухайлбал «Праманасамччая»-гийн төвд тайлбарт хийсэн ариутгал⁷-ыг хэлж болох юм. Тэгэхээр уг зохиол нь мөн зохиогчийн «сүнбум»-д ороогүй гар бичмэлээр байсан байж болох үндэстэй юм. г) Иймд Аграмба Дандарын тайлбарыг эрэн сурвалжилж судалгааны хүрээнд оруулбал чухал юм. Ийнхүү бид гавьж Дамдинсүрэнгийн «Янжиндогийн тайлбар»-ын төгсгөлийн үгийг товч тайлбартайгаар нийтэллээ. Цаашид бол нарийвчилсан судалгааг хийх болно.

Дамдинсүрэн гавьжийн бичсэн энэ тайлбар болон уг номын төгсгөлийн үгэнд нэр дурдагдсан номын нэрээс үзэхэд Төвд Монголын эрдэмтэд санскрит хэлний талаар судалгаа шинжилгээний чухал ач холбогдолтой бүтээлүүдийг туурвиж байсан байна. Иймд манай мэргэжилтэн нар Төвд Монголын эрдэмтдээс санскрит хэл зүйн талаар бичсэн бүтээлийг, нэн ялангуяа Монгол зохиогчийн төвд хэлээр бичсэн санскрит хэл зүйн бүтээлийг судалгааны хүрээнд оруулах нь чухал шаардлагатай бөгөөд энэ нь санскрит хэл зүйн судлалд өчүүхэн ч гэсэн хувь нэмэр болох юм.

Агваандамдинсүрэн буюу Дамдинсүрэн гавьжийн «сүнбум»-буюу зохиолын эмхтгэлд орсон бүтээлүүдийн товъёог:

1a. mkhas grub chen po bka' 'gyur pa dka' bcu Ngag-dbang-rta-mgrin srung-dpal-bzang po'i gsung rtzom gyi dkar chag brgyud yig bcas bzhuqs so//

1b. (1) Na mo gu ru bhyar sping rta chen po'l lam srol brang/ bgrin pa'i lam nas 'dome mdzad de/bstan bsrung spel skyong bla ma la//dad pa'i

(2) yid kyis phag bgyi'o//rgyal ba'i brtan pa che 'dzin skyong spel ba la gran zla dang ba'i nges pa don gyi zhwa ser bstan pa'i srog shing chen po rigs kun khyab bdag bka' 'gyur chin

(3) po dka' bcu Ngag-dbang-rte-mgrin-bsrung-dpal-bzang po'i gsung thor bu'i dkar chag dang brgyud rim 'god pa la (1)*. rtza ba'i la ma la 'dod don zhu ba'i gsol 'debs/ (2). rje btzun dam pa sku phreng brgyad pa'i

(4) bka' rtzom thog ma bde ldan ma 'grel ba 'od stong ma/ (3). thub dbang gnas brtan bcu drug 'khor bcas la mchod cing gsol ba btab ba'i tsul don gnyis lhun grub ma...31/

(5) (4). rgyal ba sengge'i nga ro'i zhing khams ngo mtsar rmad byung bkod par skye ba'i gser gyi them skas...18/ (5). sambha la'i zhing gi bkod pa'i 'don sgrig chos rgyal rigs ldan nams

(6) la mchod pa'i cho ga ka la bar grod pa'i myur lam... 27/ (6). sam bha la 'pho bo mdor bsdus nyams su len tsul.../ (7). byams pa gtzo bor song ba'i gsang ba 'dus pa'i ngag

(7) don rje btzun byams pa'i sku dngos su mthong ba'i me long.../ dpal rdo rje 'jigs byed la bsten pa'i bla ma'i rnal 'byor:

(8). dpe rgyan so gnyis kyi sgo nas rje bla ma bstod pa.../ (9).

(8) (10). rje btzun 'sgrol ma'i mandal bzhi ba'i cho ga mdor bsdus phan bde 'dod jo.../ (11). bka' 'gyur rin po che'i bklag tsul gyi cho ga rgyas 'bring bsdus gsum...spar thung...19/

2a. (1) (12). phyag na rdo rje'i sgrub thabs dud las rnam rgyal...12/ (13). de'i sgrub thabs khyer bde s nye ma...spar thung...5/ nyam len bskul ma.../ (15). bka' gdams glegs bam

(2) las jo bo yab sras kyi skye 'phreng tsigs bcad du bsdebs ba.../ (16). de'i nang nas nor bu 'phreng da'i tsigs bcad sogs logs su bkar ba.../ (17). bslab bya the bzhi ...spar thung...3/

(3) (18). byang chub sams dpa'i sdom pa nyi shu pa'i don grel gzhung lam rjes 'jug.../ (19). gsang sngags tsul khirms kyi bslab bya nam bzhag mdo tzam briod pa 'jam

(4) mgon bla ma'i zhal lung... (20). **A-nu-bhu-ti gsal ldan gyi lde mig...** (21). tse dpag med kyi tsogs mchod mgon po tse dpeg med mnyes par byed pa'i mchod sprin bkra shes char 'bebs.../ (22). rje btzun byams

(5) mgon mnyes byed mchod sprin dngos grub char 'bebs.../ (23). 'phags pa spyen ras gzigis kyi tsogs 'khor mdor bsdus bkra shes char 'bebs... /

(6) (24). dar han sogs la sangs mchod 'bul tsul... (25). bde ba can gyi zhing du skye ba 'dzing pa'i smon tsig bde ldan zhing gi sgo. 'byed.../ (26). 'dod don sna tsogs lhung grub smon tsig

(7) yid kyi re bskong ma spar thung.../ (27). rje btzung byam pa la bya rgyud mthun par tsogs mchod 'bul tsul...! (28). rje btzung sgröl ma sloka gcig.../

brgyud yig

2b. (1) ...rnam las rtaqs med rnam kyi rgyud pa mi mdzad pa po rdo 'chang nyid nas/ phran slob bu bdag Blo-bzang-bzad-pa-rgyam mtso la dgyes bzhin du stzal lags sol/

(2) ...rtaqs can gyi brgyud pa ni/ mdzad pa po ni/ sngags rams pa Blo-bzang-rgyal-mtsan-bzang-po/ bka' bcu Tse-ring-dpal-ldan: rdo rje 'chang sngags rams pa Tse-ring-dkon-mchog-rdo-rje-bzang-po/ des bdag la'oll

+ Гарчигт орсон номын дугаарласан тоо

(3) sngags ...rtags can gyi brgyud ni/ mdzad pa po ni/ sngags rams pa Ngag-dbang-tse-dpag/ rje slob dpon rin po che Tse-ring-dkon (mchog) rDo-rje-dpal-bzang-po/ des bdag la'o//

1. Шинжлэх Ухаан Амьдрал (сэтгүүл) УБ., 1985, № 1, 57-59-р тал
2. gombojab.S, Monvolcud töbed kele-ber jokiyavsan jokiyalun juyil, - Tom. 1., Fasc, 28. , UB. 1961.
3. Монголын судлал. Том. VII/15/, Fasc,2,, 1982., 48-р
4. Р. Бямбаа «Лувсандаш төвд хэл бичгийн шинжлэлтэн болох нь ШИНЖЛЭХ УХААН ЗАЛУУЧУУД (өгүүллийн эмхтгэл) УБ., 1987
5. Төвд эх Дэргэ Данжуур 217-р боть., 92—98-р тал Монгол эх Монгол Данжуур, 197-р боть, 1—10-р тал
6. Мөн тэнд, 197-р боть, 10—125-р тал.
7. Р. Бямбаа, «Праманасамуччая»-гийн төвд тайлбарт хийсэн Дандар аграмбагийн ариутгал», Дорнодахны судлалын асуудал (сэтгүүл) УБ., 1987, 65-р тал.

**СИНЬЦЗЯН — УЙГАРЫН АВТОНОМИТ
РАОЙН ДАХЬ ХЯТАД БИШ АРД ТҮМНИЙ
СОЁЛЫН ӨВ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

**М. Хурметхан
Ч. Батцэцэг**

Социалист соёлын бүтээн байгуулалтад эртний соёлын өв уламжлал чухал байр эзэлдэг юм. В. И. Ленин соёлын өвийг социалист нийгмийн маш чухал «бүтээн байгуулах материалын» нэгэн хэсэг хэмээн үзэж байв. В. И. Ленин хүн төрөлхтний өмнөх эд өлгийн болон оюун санаанд хүрсэн тэр үнэ цэнэтэй, дэвшилттэй зүйлийг социалист нийгэмд эзэмшиж, амьдрал практикт ашиглах нь онцгой чухал ач холбогдолтой гэж заасан билээ. В. И. Ленин бичихдээ: «Хөрөнгөтний болон капитализмын соёлыг бий болгосон соёл, техник, арга хэрэгслийг авч хэрэглэхгүйгээр социализмыг байгуулашгүй юм»¹ гээд «Капитализмын соёлоос авч, социализмыг бүтээн байгуулахад хэрэглэх хэрэгтэй. Ингэхгүйгээр бид коммунист нийгмийн амьдралыг байгуулж чадахгүй»² гэжээ. В. И. Ленин бүх соёлын тухай ярихдаа хуучин нийг мийн хаях ёстой зүйл, устгаж арилгавал зохих зүйлийг, хадгалж үлдэх зүйлээс ялган үзэж байв.

БНХАУ байгуулагдсаны дараа тус оронд үндэстний соёлын өвд нааштай хандах, соёлын өвийг цуглуулах, судлах, хамгаалах талаар нэлээд ажил хийж эхлэв. ХКН-аас БНХАУ байгуулагдсаны дараа хятад биш бусад үндэстний нэг адил Синьцзян-Уйгарын автономит